



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 07/10

Эрдэнэт


“Төлөөлөгчийн ёс зүйн
дүрэм” батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2. Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ёс зүйн хороонд тус тус даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

079130026



АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН “ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ”

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ дүрмийн зорилго нь аймгийн иргэдийн Төлөөлөгч нь (цаашид “төлөөлөгч” гэх) хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд баримтлах, нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, төлөөлөгчийн нэр хүндийг хамгаалах, төлөөлөгч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Төлөөлөгч нь үйл ажиллагаандаа энэхүү дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг баримтлахын зэрэгцээ, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хэм хэмжээг дагаж мөрдөнө.

1.3.Төлөөлөгч ёс зүйн зөрчил гаргах нь иргэд, олон нийт, иргэний нийгмийн зүгээс төлөөлөгчид итгэх, итгэлийг алдагдуулах, нутгийн өөрөө удирдах байгууллагын нэр хүндийг бууруулах сөрөг үр дагавартай тул төлөөлөгч бүр ёс зүйн хэм хэмжээг чанд сахин мөрдвөл зохино.

1.4.Энэхүү дүрмээр зохицуулаагүй асуудал гарсан тохиолдолд холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу шийдвэрлэнэ.

Хоёр. Төлөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээ

2.1. Төлөөлөгч нь бүрэн эрхийнхээ хугацаанд дараах ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөнө:

- 2.1.1.орон нутгийн бие даасан байдал, иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг эрхэмлэх;
- 2.1.2.төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэх;
- 2.1.3.Үндсэн хууль, хууль ёсыг дээдлэн сахиж биелүүлэх;
- 2.1.4.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 2.1.5.биеэ авч явах, шударга байдлаараа үлгэр дуурайл үзүүлэх.

2.2.Төлөөлөгч нь энэ дүрмийн 2.1-д заасан ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөхөөс гадна дараах ёс зүйн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй:

- 2.2.1.Төлөөлөгч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ баримтлах ёс зүйн шаардлага;
- 2.2.2.ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой ёс зүйн шаардлага;
- 2.2.3.албан томилолт болон хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой ёс зүйн шаардлага;
- 2.2.4.шагнал, бэлэг дурсгал хүлээн авахтай холбоотой ёс зүйн шаардлага;

Гурав.Төлөөлөгч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ баримтлах ёс зүйн шаардлага

3.1.Төлөөлөгч өвчтэй, чөлөөтэй, албан томилолтоор ажиллахаас бусад тохиолдолд аймгийн ИТХ-ын хуралдаан, Хурлын зөвлөл болон Хорооны хуралдаанд товлосон хугацаанд ирж оролцох үүрэгтэй.

3.2.Төлөөлөгч цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон ургалч үзлийн үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг баримтална.

3.3.Төлөөлөгч нь өвчтэй буюу өвчтэй хүн асарсан бол эмнэлгийн магадлагаа, гадаад, дотоод албан томилолтоор явсан тохиолдолд томилолтын хуудасны хуулбарыг (цахимаар) аймгийн ИТХ-ын Ажлын албанд хүргүүлнэ.

3.4.Аймгийн ИТХ-ын хуралдаан болон Хурлын зөвлөлийн хуралдааны дэг зөрчиж, хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, хуралдаанд үг хэлэх, байр сууриа илэрхийлэхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдын нэр төр, алдар хүндийг гутаах, доромжлохыг хориглоно.

3.5.Төлөөлөгч нь үзэл бодол, байр сууриа илэрхийлэхдээ албан ёсны эх сурвалжийг баримтлах ба олон нийтийг төөрөгдүүлэх, үндэслэлгүй мэдээлэл хийхийг хориглоно.

3.6.Төлөөлөгч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хувийн ашиг сонирхлоор хэн нэг хүн, хэсэг бүлэг хүмүүс, байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжихийг хориглоно.

3.7.Төлөөлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн хамаарал бүхий этгээдэд давуу байдал бий болгох зорилгоор хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, санал хураалтад оролцохыг хориглоно.

3.8.Төлөөлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ нууцын тухай хууль тогтоомжийг баримталж, төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалсан нууцыг чанд хадгална.

3.9.Төлөөлөгч төрийн албан хаагчаар албаны чиг үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхээр заавар, чиглэл өгөх, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш үйлдэл, эс үйлдэхүй хийхийг шаардахыг хориглоно.

Дөрөв. Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой ёс зүйн шаардлага

4.1.Төлөөлөгч ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, улс төрийн үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баримталж ажиллана.

4.2.Төлөөлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аливаа асуудлаар гадаадын байгууллага, албан тушаалтанд амлалт өгөхгүй байх, мөн гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллагын нөлөөнд орж орон нутгийн ашиг сонирхолд харшлах үйлдэл хийхийг хориглоно.

4.3.Төлөөлөгчийн нэр хүнд, бүрэн эрхийг гэр бүлийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн санхүүгийн байдлыг дээшлүүлэхэд ашиглахыг хориглоно.

4.4.Төлөөлөгч бүрэн эрхийн хугацаанд хуульд зааснаас бусад тохиолдолд иргэн, хуулийн этгээдээс хандив, мөнгөн хөрөнгө, шан харамж гаргахыг зуучлах, санал болгохыг хориглоно.

4.5.Ажил үүргийн дагуу олж авсан мэдээ, мэдээллийг хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх, бусдад ашиглуулахыг хориглоно.

4.6.Төлөөлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын ашиг сонирхлын нөлөөнд автах, эдийн засгийн хараат байдалд орохыг хориглоно.

4.7.Төлөөлөгч хууль тогтоомжоор хориглосон аливаа ажил, албан тушаал эрхлэх, түүнчлэн цалин хөлс, урамшуулал авах, өгөхийг шаардахыг хориглоно.

4.8.Хэлэлцэж байгаа асуудал нь ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол төлөөлөгч энэ тухай хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж, санал хураалтад оролцохоос сайн дураараа татгалзана.

4.9.Төлөөлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.

Тав. Албан томилолт болон хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой ёс зүйн шаардлага

5.1.Төлөөлөгч нь албан томилолтоор ажиллахдаа батлагдсан удирдамж, чиглэлийг чанд баримтлан ажиллана.

5.2.Төлөөлөгч нь гадаад улсад албан томилолтоор ажиллахдаа Монгол улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байж дипломат ёсыг чанд баримтлах үүрэгтэй.

5.3.Төлөөлөгч хөрөнгө, орлогын мэдүүлгийг хууль тогтоомжид заасан хугацаанд өөрийн болон гэр бүлийнхээ хөрөнгө, орлогыг бүрэн, үнэн зөвөөр мэдүүлж байх үүрэгтэй.

Зургаа.Шагнал, бэлэг дурсгал хүлээн авахтай холбоотой ёс зүйн шаардлага

6.1.Төлөөлөгч нь гадаад орны төрийн дээд цол, одон медаль, төрийн бусад шагнал авахыг хориглоно.

6.2.Төлөөлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын иргэн, хуулийн этгээдэд хууль бус давуу байдал олгох, үгсэн тохирох, амлалт өгөх, бэлэг, шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, эсхүл эдгээрийг хүсэх, шаардах замаар эдийн болон эдийн бус эрх олж авахыг хориглоно.

6.3.Төлөөлөгч эрх мэдлийнхээ хүрээнд хянан шалгаж байгаа байгууллага, албан тушаалтнаас бэлэн мөнгө болон мөнгөөр үнэлэгдэх үнэт зүйлс, үнэ төлбөргүйгээр үйлчилгээ авахыг хориглоно.

Долоо.Төлөөлөгчийн эрх ашгаа хамгаалуулах эрх

7.1.Хэрэв төлөөлөгчийн талаар үндэслэлгүй нийтлэл хэвлүүлсэн, нэвтрүүлсэн тохиолдолд тухайн төлөөлөгч, эсвэл түүний эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага шүүхэд хандаж, төлөөлөгчийн нэр хүндийг сэргээлгэх, эд хөрөнгийн бус гэм хорын хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй.

Найм.Төлөөлөгчийн ёс зүйн зөрчил, түүнийг шалган шийдвэрлэх

8.1.Төлөөлөгчийн ёс зүйн зөрчил гэж энэ дүрмээр тогтоосон төлөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

8.2. Ёс зүйн хороо нь аймгийн ИТХ-ын ажлын албаар дамжуулан төлөөлөгчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой дараах гомдол, өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авна:

8.2.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нэр дээр иргэд, хуулийн этгээдээс төлөөлөгчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой бичгээр ирүүлсэн гомдол, өргөдөл, мэдээлэл;

8.2.2. Ёс зүйн хороонд иргэн, хуулийн этгээдээс бичгээр ирүүлсэн гомдол, өргөдөл, мэдээлэл;

8.3. Ёс зүйн хороо нь төлөөлөгчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, аймгийн ИТХ-ын төлөөлөгчийн ёс зүйн дүрмийн дагуу хянан шийдвэрлэнэ.

8.4. Ёс зүйн хороо дараах өргөдөл, гомдол, мэдээллийг хянан үзэхгүй:

8.4.1. нэр, хаяг, гарын үсэггүй өргөдөл, гомдол, мэдээллийг аймгийн ИТХ-ын дарга, Ёс зүйн хорооноос хянан үзэхгүйгээр буцаана;

8.4.2. Төлөөлөгчийн бүрэн эрх нь хэрэгжиж эхэлснээс өмнөх хугацаанд гарсан ёс зүйн зөрчлийн асуудлаар хандсан гомдол, мэдээлэл;

8.4.3. Төлөөлөгчийн нэр хүндийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гутаан доромжилсон асуудлаар эрх нь зөрчигдсөн этгээдээс бусад этгээдийн ирүүлсэн гомдол, өргөдөл, мэдээлэл;

8.4.4. Төлөөлөгчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой тухайн асуудлаар өмнө нь хандаж, албан ёсны хариу авсан бол;

8.4.5. Төлөөлөгчийн ёс зүйн зөрчлийн асуудал нь хууль, хяналтын байгууллагад шалгагдаж байгаа тохиолдолд.

8.5. Төлөөлөгчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, өргөдөл, мэдээллийг Ёс зүйн хорооны дарга хүлээн авч, ёс зүйн хороо хянан шалгаж, хорооны санал дүгнэлт гаргана.

8.5.1. Ёс зүйн хороо гомдол, мэдээлэлд холбогдсон төлөөлөгчтэй уулзаж, тайлбар, саналыг сонсож тэмдэглэл хөтлөх;

8.5.2. Ёс зүйн хороо нь шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагаас баримт бичиг, тайлбар, бусад лавлагаа материалыг гаргуулж авах;

8.6. Шалгалтын явцад төлөөлөгчийн ёс зүйн зөрчлийн шинж байдалд ёс зүйн хариуцлага тооцохооргүй бол шалгалтын дүнг үндэслэн Ёс зүйн хороо тухайн төлөөлөгчийг дуудаж уулзан, зөвлөгөө өгнө.

8.7. Шалгалтын явцад гомдол, өргөдөл, мэдээлэлд дурдсанаар төлөөлөгч нь энэ дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн нь нотлогдвол тухайн төлөөлөгчид сахилгын хариуцлага оногдуулах үндэслэл болох бөгөөд Ёс зүйн хорооны санал дүгнэлтийг 30 хоногийн дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

Ёс. Ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

9.1. Төлөөлөгчийн ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийн талаарх Ёс зүйн хорооны санал дүгнэлтийг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж, ёс зүйн зөрчлийн шинж байдлыг харгалзан дараах сахилгын хариуцлага ногдуулна:

9.1.1. Сануулга өгөх;

9.1.2.Уучлал гуйхыг үүрэг болгох;

9.1.3.Төлөөлөгчийн сарын урамшууллын зардлаас 6 сар хүртэл хугацаагаар, 20 хүртэл хувиар бууруулах

9.2.Энэ дүрмийн 9.1-д заасан хариуцлагыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоолоор ногдуулна.

9.3.Төлөөлөгч энэ дүрмийн 9.1.2-т заасан хариуцлага хүлээх шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор сайн дураараа биелүүлж, энэ тухайгаа Ёс зүйн хороонд бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв энэ үүргээ биелүүлээгүй бол Ёс зүйн хороо нь тухайн төлөөлөгчид ногдуулсан ёс зүйн хариуцлагыг биелүүлээгүй талаар олон нийтэд албан ёсоор мэдээлнэ.

9.4.Төлөөлөгчийн ёс зүйн зөрчлийн хэм хэмжээ нь гэмт хэргийн болон авлигын шинжтэй бол харьяаллын дагуу холбогдох байгууллагад албан бичгээр шилжүүлнэ.

9.5.Энэ дүрмийн 9.1-д заасан хариуцлагыг төлөөлөгчид ногдуулсан талаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын албан ёсны цахим хуудаст ажлын 5 өдрийн дотор нийтэлнэ.

9.6.Төлөөлөгчийн үйлдсэн ёс зүйн зөрчилд энэ бүлэгт заасан хариуцлагын төрлийг давхардуулан ногдуулахгүй.

9.7.Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн бол төлөөлөгчид 9.1-д заасан хариуцлага ногдуулж болохгүй.

9.8.Төлөөлөгч нь сахилгын хариуцлага оногдуулсан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор шүүхэд гаргаж болно.

9.9.Ёс зүйн хорооны хуралдаанаар төлөөлөгчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн эсэх, хэрхэн шийдвэрлэсэн талаар гомдол, мэдээлэл гаргасан иргэн, байгууллагад албан бичгээр хариу өгнө.

Арав.Бусад

10.1.Энэ дүрмийн хэрэгжилтийг Ёс зүйн хороо хариуцаж, хяналт тавьж ажиллана.

10.2.Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжих ба шаардлагатай гэж үзвэл аймгийн ИТХ-ын хуралдаанаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

---oOo---